

ШҮТЭН БАРИЛДЛАГЫН МАГТААЛ САЙН НОМЛОЛЫН ЗҮРХЭН ХЭМЭЭХ ОРШВОЙ

Намо гүрү Манзугохаяа

Багш Зөөлөн Цогт дор мөргөмү

1. Алиныг болгоон номлосноор

Ханьцашгүй Айлдалт багш болсон,

Ахуйн ёс шүтэн барилдлагыг

Болгоон номлосон Бухан түүнд дор мөргөмү

2. Ертөнцийн доройтол бүгд

Ер түүний үндэс нь мунхаг агаад

Алимад шүтэн барилдлагыг мэдсэнээр

Аюул түүнийг буцаана хэмээн зарлиглав

3. Тэр цагт төгс ухаант хэн бээр

Төв шүтэн барилдлагын мөрийг

Таны шашны гагц аньс хэмээн

Таалахгүй байж яахин чадах.

4. Тийм учраас итгэл таныг магтах

Магтаалын дундаас хэн нэгэн бээр

Ахуй шүтэн барилдлагыг номлогч хэмээх

Агуу гайхамшигт магтаалыг яахин олох.

5. “Аль алин шалтгаанд харгалзваас

Тэр тэр нь өөрийн чанараар хоосон” хэмээх

Ийм номлолоос илүү гайхамшигт

Энгүй айлдвар хаанаас байх вэ.

6. Эгэл нялхсын хувьд энэ нь

Эцэслэн баригч хүлээсийг бататгана

Эрдэмт мэргэдийн хувьд тэр нь

Эндүү туурвил бүгдийг таслах үүд болно

7. Зөв ийм номлол бусдад үгүй тул

Зөвхан тал “Багш” хэмээгдэх болюу

Тэрсүүдийн номлогчийг багш хэмээвэл

Тэрс үнэгийг арслан хэмээн зусардах мэт.

8. Гайхамшигт багш, гайхамшигт аврал,

Гайхамшигт өгүүлэгч, гайхамшигт итгэл,

Гарцаагүй шүтэн барилдлагыг номлогч

Гагц багш түүн дор би мөргөмү

9. Асар тусыг зохиогч таны айлдсан

Амьтныг анагаах сургаал номлолын

Амин шим хоосон чанарыг

Анддууралгүй магадлахын дээд нотолгоо

10. Харилцан шүтэлцэхүйн ёс үүнийг

Харшлах ба эс бүтэх нотолгоонд

Андууран баригч тэд бээр таны ёсыг

Аяа, яахин таньж чадах билээ

11. Эрхэм та хэзээ нэгэнтээ хоосон чанарыг

Эл шүтэн барилдлагын утганд ухаарвал

Өөрийн чанараас хоосон лугаа

Үйл үйлдлийн зохицол үл харшлах бөгөөд

12. Харин түүнээс ангид сэтгэн ухаарвал

Хоосон чанарт үйлдэл зохисгүй ба

Үйл лугаа сэлтэд ч хоосон чанар зохисгүй тул

Үлэмж халилд унана хэмээн таалсан.

13. Тиймийн тул таны шашин дор

Шүтэн барилдлагыг ухаарахыг сайтар сайшаав.

Тэр нь ч огт үгүй хийгээд

Өөрийн чанараар байгаа ч бус

14. Юунаас ч эс гавъяатах огторгуйн цэцэг мэт,

Тиймийн тул үл шүтэгч үгүй бөгөөд

Мөн чанараар бүтвээс түүний орших нь

Шалтгаан нөхцөл харгалзахад харш болно

15. Тийм учраас шүтэн барилдлагаас

Тусгаар юмс огт үгүй бөгөөд

Өөрийн чанараар хоосноос ч

Өөр ангид юмс огт үгүй хэмээн номлов

16. Юмсад өчүүхэн өөрийн чанар байдагсан бол

Ер өөрийн чанар үл буцах тул

Гаслангаас нөгцөх нь зохисгүй бөгөөд

Гай туурвил буцахгүй гэж номлов.

17. Аяа, өөрийн чанараар ангижирсан хэмээн

Арслангийн дуугаар мэргэдийн чуулганд

Ахин дахин сайтар номлосон

Алин түүнийг хэн эсэргүүцэн чадах

18. Өөрийн чанар өчүүхэн ч үгүй хийгээд

Үүнд шүтэн энэ гарах

Таацсан агуулга эл хоёр

Таацах үл харшлах үүнийг хэлэх юун

19. Эл шүтэн барилдлагын шалтгаанаар

Эцэслэн баримтлах үзэлд үл шүтнэ хэмээн

Сайтар номлосон энэ итгэлт таны

Сац ханьцашгүй өгүүлэхийн уг шалтгаан мөн

20. Мэдэгдэхүүн бүгд мөн чанараар хоосон ба

Магад шалтгаанаас үр гарахын

Инагш чинагш хоёр магадлалыг

Яав ч харшуулалгүй нөхөрлүүлвээс

21. Үүнээс гайхамшигтай хийгээд

Үүнээс тансаг юу байх вэ.

Энэ ёсоор таныг магтвас

Эрхэм магтаал буюу, бусад нь үгүй.

22. Балай мунхагийн боол болсон

Балмад нэг нь тантай мөчөөрхөгч

Өөрийн чанар үгүйн дуунд

Үл тэсэхийг гайхах хэрэг юун

23. Авралт таны зарлигийн энхрий сан

Ахуй шүтэн барилдлагыг зөвшөөрөөд

Агуу хоосон чанарын дуунд үл тэсэгч

Алин түүнийг би бээр гайхмуй.

24. Тийн өөрийн чанаргүйд хөтлөхүйн үүд

Тэнцэлгүй шүтэлцэн гарах ёсыг

Эл нэр төдийгөөр өөрийн чанарт

Эндүүрэн барьдаг төрөлхийтөн тэднийг

25. Хутагт дээдсийн сайтар зорчдог

Хосгүй дээдийн орох олом

Авралт таныг баясуулах мөр түүнд

Арга юугаар хөтлөн үйлдэх вэ?

26. Завсаргүй ба харгалздаггүй өөрийн чанар

Завсартай бөгөөд харгалздаг шүтэн барилдлага хоёр

Хамт нэгэн суурин дээр

Харшлалгүй яахин хурж болох вэ

27. Иймийн учир шүтэн барилдсан юмс

Өөрийн чанараас уг язгуураар

Ямагт машид аглаг мэт үзэгддэг тул

Юмс үзэгдэл эдгээрийг илбэ хэмээн номлов

28. Эгэлгүй таны ямар мэт айлдсанд

Эсэргүүцэгч хэн нэгэн ном лугаа зохилдсон

Буруутгах чөлөөг үл олно хэмээн номлосныг

Бас энэ ямагтаар л сайтар мэдмү за.

29. Яагаад гэвэл үүнийг номлосноор

Ямарваа үзэгдэх, эс үзэгдэх юмст

Үгүйсгэх хийгээд хэтрүүлэхийн

Үесийг холтгон зохиосны тул болой

30. Жишишгүй мэргэн өгүүлэгч болохыг тань

Жишээлэн мэдэхийн нотолгоо болсон

Шүтэн барилдлагын мөрөөр бусад зарлигийг тань

Шалгарсан үнэнд барих магадлалыг олмуй

31. Бишрэлт таны шашнаас гадагш зүглэвээс

Бэрхшээл алжаалыг өнө удаан шүтсэн ч

Харин жич гэмүүдийг дуудсан мэт

Харалган “би”-д барих үзэл бататмуй

32. Аяа, мэргэд бээр энэ хоёрын

Асар ялгамжааг танин бариваас л

Агшин түүнээ үнэн зүрхний угаас

Авралт танд яахин бишрэхгүй билээ

33. Зүйрлэшгүй таны олон зарлигийг хэлэх юун

Зүйл нижгээдийн хувь утганд ч

Барагцаа төдий ойлгоц авбаас

Барагдашгүй дээдийн амгаланг өгмүй

34. Ай хөө, миний оюун мунхагт автжээ

Агуу эрдмийн цогц энэ мэтийг

Аль эртнээс авралд барьсан ч

Ачит эрдмийн тань хувь төдийг үл мэджээ

35. Гэвч үхлийн эзний ам руу зүглэсэн

Амин судал минь тасраагүй бөгөөд

Авралт таньд өчүүхэн итгэсэнээ

Аяа, сайн хувь хэмээн бахархмуй

36. Багшийн дотроос шүтэн барилдлагыг заагч

Билгүүний дотроос шүтэн барилдлагыг мэдэгч хоёр

Хамаг ертөнцөд ялгуулсны эрхэт адил

Хэтэрхий сайныг та л айлдана, бусад нь үгүй

37. Гайхамшигт таны зарлигласан бүгд

Гагц шүтэн барилдлагаас туурвин орно

Тэр нь ч гаслангаас нөхцөхийн тулд бөгөөд

Тийн амирлахаас бусад зохиол таньд үгүй

38. Аяа, таны авралт шашин

Алин нэгний чихэнд дуурсваас

Тэдгээр бүгд амирлах тул

Таны шашныг барихад хэн бээр үл бишрэх вэ.

39. Чинад эсэргүүцэгч бүгдийг дарсан,

Чинагч инагш эх адаг нь хутгалдан харшаагүй,

Бүхий л төрөлхтний хоёр тусыг хайрлагч

Бишрэм ёс үүнд миний дуршил арвитмуй

40. Эгнэшгүй олон галваар

Иймийн тулд энэрэлт та бээр

Энхрий садан, эд таваарын чуулганаа

Эргэлт буцалтгүй ахин дахин зориулсан

41. Гайхамшигт эрдмийг тань мэдсэнээр

Гох дэгээнд татагдсан загас адил

Тааллыг тань булаасан ном үүнийг

Таниас эс сонссон тул хувь дутуу ажээ

42. Энд энэлэн гасалсны хүчээр

Энхрий хүүдээ эхийн сэтгэл

Үргэлж зовнихын нэгэн адил

Эгээрч миний сэтгэлийг бүү орхи

43. Бас таны зарлигийг санаваас

Билиг найргийн цог бадарсан

Ариун гэрлийн тороор дүүрэн хүрээлэгдсэн

Авралт багш бээр Эсүрвагийн эгшигээр

44. Үүнийг энэ мэт номлоно хэмээн

Үнэн Чадагчын дүр хөрөг сэтгэлд

Илрэн ургамагц халуун энэлгээ

Ээлт сарны гэрэлд сэрүүцэх мэт тустай

45. Тар адилын хэтэрхий гайхамшигт

Тэргүүн ёс түүнийг мэргэн бус

Өтөл ардууд хялгана өвс мэт

Үй зайгүй ширэлдүүлж үйлджээ

46. Байдал үүнийг би бээр үзээд

Буцалтгүй хичээлээр олон мэргэдийг

Даган бараадаад итгэлт таны

Дархан тааллыг дахин дахин хайв

47. Бас тэр цагт өөр бусад аймгийн

Барагдашгүй олон номыг судлахад

Харин жич сэжгийн тороор

Хамгаас миний сэтгэл машид энэлэв

48. Бурхан таны ханьцашгүй хөлгөний ёсыг

Буй хийгээд үгүйн хязгаарт тэвчин

Буруугүй таны тайлбарлахад эш олсон

Богд Нагаржунайн гол ёсны гүмүда цэцэрлэг нь

49. Хиргүй айлдлын хот мандал дэлгэрсэн

Хосгүй зарлигийн огторгуйд торолтгүй явагч

Эцэслэн барихын зүрхний харанхуйг арилгагч

Эндүүрэлгүй өгүүлэгчдийн од гаригийг сүрээр дарагч

50. Цогт Чандракиртийн сайн номлолын

Цагаан гэрлээр тодрон үйлдсэнийг

Авралт багшийн ачаар мэдсэн тэр цагт

Аяа, миний сэтгэл амирлалыг олов оо.

51. Үйлс зохиол бүгдийн дундаас

Үнэхээр зарлигийн зохиол дээд бөгөөд

Үлэмж тэр нь энэ ямагт мөний тул

Үүгээр мэргэд бурханыг дурьдан дагатугай

52. Эгнэшгүй багш түүнийг ч даган хувраг болоод

Эрхэм бурханы зарлигийг сайтар судалсан

Ирмүүн ёогийн явдал хичээгч нэгэн гэлэн

Их арш түүнээ ийнхүү биширвээ.

53. Зүйрлэшгүй Үзүүлэгчийн шашин лугаа

Золоор учирсан энэ нь багшийн ач мөн тул

Ариун буян үүнийг амьтан бүгд

Ачин буяны саднаар эзлэгдэхийн угт зориулмуй

54. Магад туслагч таны шашин цагийн эцэстээ

Муу атгагийн салхиар үл хөдлөөд

Ариун шашны авир ёсыг мэдээд

Авралт бурханд итгэгчдээр ашид дүүрэх болтугай

55. Шүтэн барилдлагын утга чанарыг тодруулсан

Чадагчийн сайн ёсыг төрөл тутамд

Амь хийгээд биеэ зориулан барихдаа

Агшин төдий үл султгах болтугай

56. Дээд Сартваах тэр бээр цагшлашгүй бэрхшээлээр

Даамай шамдлаар зүрхэнд барьж бүтээсэн

Алин аргаар арвижуулах вэ хэмээсэн үүнийг

Алгасарлгүй шинжлэлээр өдөр шөнийг нөгцөөх болтугай

57. Үлэмж ариун сэтгэлээр тэр ёсонд хичээхэд

Эсүрэн ба Хурмаст ертөнцийг тэтгэгчид,

Их Махгал тэргүүтэй сахиуснууд ч

Эгшин ч алгасралгүй үргэлж нөхөрлөх болтугай